

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр

№ 25/51

Улаанбаатар хот

Мэдээллийн технологийн аудитор томилох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, 81 дүгээр зүйлийн 81.4.2 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 14 дүгээр зүйлийн 14.5.2 дахь заалт, 16 дугаар зүйл, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн үйл ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 2.9.4 дахь заалт, Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн АХ-25/10 тоот дүгнэлт болон Компанийн ТУЗ-ийн 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Мэдээллийн технологийн аудиторын албан тушаалд Мөнхжаргал овогтой Ариунболд (РД: _____) -ыг томилсугай.
2. М.Ариунболдын цалин, урамшууллыг ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороотой зөвшилцсөний үндсэн дээр тогтоохыг Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д зөвшөөрсүгэй.
3. Дотоод аудиторыг чиг үүргийн удирдлагаар ханган, түүний үйл ажиллагаа, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны Дарга (Ж.Жаргалсүрэн)-д үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоолын биелэлтийг хангаж ажиллах, Мэдээллийн технологийн аудитор М.Ариунболдтой Хөдөлмөрийн гэрээ болон Нууцлалын гэрээ байгуулахыг Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.

